

НАЛАЙХ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ДЭГ

1 дүгээр зүйл. Дэгийн зорилт

1.1. Энэхүү дэгийн зорилт нь Налайх дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Хурлын хороо, дэд хороо, түр хороодын хуралдаан /цаашид “хуралдаан” гэх/-ыг зохион байгуулах, хуралдаанаар тодорхой асуудал хэлэлцэх, санал хураах, шийдвэр гаргах дэг журамтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Нийтлэг үндэслэл

2.1. Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны зохион байгуулалтын үндсэн хэлбэр нь хуралдаан мөн.

2.2. Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны зохион байгуулалт, үйл ажиллагааг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль болон энэ дэгээр зохицуулна.

3 дугаар зүйл. Хуралдааны үндсэн зарчим

3.1. Хуралдаан хууль дээдлэх, асуудлыг чөлөөтэй хэлэлцэж, цөөнхийн саналыг хүндэтгэн сонсож олонхийн саналаар шийдвэрлэх зарчмыг удирдлага болгоно.

3.2. Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгч /цаашид “Хурлын төлөөлөгч гэх”/ хуралдааныг товлон зарласан цагт хүрэлцэн ирэх үүрэгтэй.

4 дүгээр зүйл. Хуралдааны тов, ирц ба хэлэлцэх асуудал

4.1. Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын /цаашид “Хурал” гэх/ ээлжит хуралдааныг улиралд 1-ээс доошгүй удаа өөрийн онцгой бүрэн эрх болон хууль тогтоомжид заасан бусад эрхэд хамаарах асуудлын хүрээнд тогтмол хуралдуулна.

4.2. Цаг үеийн шаардлагатай асуудлаар Хурлын Тэргүүлэгчид энэ дэгийн 4.1-д заасан ээлжит хуралдааны чөлөө цагт хуульд заасан өөрийн бүрэн эрхийн асуудлаар хуралдаж тогтоол гаргах бөгөөд энэ талаар Хуралд мэдэгдэж байна.

4.3. Хурлын хуралдааны бэлтгэл хангах, хэлэлцэх асуудал боловсруулах зорилгоор нам, эвслийн бүлэг, Хурлын хороо, дэд хороо, түр хороодын хуралдааныг хуралдуулна.

4.4. Хурлын ээлжит ба ээлжит бус хуралдааны хэлэлцэх асуудлыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар тогтоож таваас доошгүй хоногийн өмнө зарлах бөгөөд Хурлын төлөөлөгч болон дүүргийн Засаг дарга нь хурлын хэлэлцэх асуудлын дараалалд асуудал оруулж хэлэлцүүлж болно.

4.5. Хуралдааныг Нам, эвслийн бүлгийн саналаар түр завсарлуулах буюу хугацааг нь сунгаж болно. Завсарлагыг эхний удаад 2 цаг хүртэл, дараагийн удаа 1 цаг хүртэлх хугацаагаар авах бөгөөд хэдий хугацаагаар авахыг хуралдаан дээр зарлана.

4.6. Хуралдаанд бүрэн эрх нь хүлээн зөвшөөрөгдсөн нийт төлөөлөгчийн олонх оролцсоноор ирцийг хүчин төгөлдөрт тооцно.

4.7. Хурлын Төлөөлөгч хуралдаанд хүндэтгэх шалтгаанаар ирэх боломжгүйд хүрвэл Хурлын дарга, Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргад мэдэгдэж, хэлэлцэх асуудалтай холбоотой саналаа урьдчилан бичгээр ирүүлж болох бөгөөд зөвхөн ирүүлсэн саналтай холбоотой асуудлыг шийдвэрлэх санал хураалтын хувьд дэмжсэн саналд тооцно. /Харин зохион байгуулалтын асуудал хэлэлцэхэд бичгээр санал ирүүлэхгүй./Хурлын ирцийг тооцоход тухайн төлөөлөгчийг оруулж тооцохгүй.

4.8. Хурлын Төлөөлөгч өвчтэй байсан буюу өвчтэй хүн асарсан, гадаад, дотоод томилолтоор явсан, түүнчлэн хурал, уулзалтад зайлшгүй оролцох шаардлагатай байсан бол хүндэтгэх шалтгаантай гэж үзэх бөгөөд эдгээр шалтгаан байхгүй бол хуралдаан тасалсанд тооцно.

4.9. Хурлын Төлөөлөгч, нам эвслийн бүлэг шалтгаангүйгээр хуралдаанд оролцохгүй байх буюу түүнийг орхиж гарахыг хориглоно.

4.10. Хурлын Төлөөлөгч, нам эвслийн бүлэг шалтгаангүйгээр хуралдаанд оролцоогүй буюу орхиж гарсан бол хуралдаанд оролцож эсрэг санал өгсөнд тооцож санал хураалт явуулна.

4.11. Хуралдаанаар Хурал өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлын зэрэгцээ эрх бүхий дээд шатны байгууллага болох Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд шийдвэрлүүлэхээр шилжүүлсэн асуудал, дүүргийн Засаг дарга болон Хурлын Тэргүүлэгчдээс өөрсдийн эрх хэмжээний асуудлыг шийдвэрлүүлэхээр оруулсан асуудлыг хэлэлцэж шийдвэрлэж болно.

4.12. Хуралдааны дэгд нэмэлт өөрчлөлт оруулах тухай асуудлыг Хурлын Төлөөлөгчдийн тавны нэгээс доошгүй саналаар ээлжит хуралдаанаар хэлэлцүүлнэ. Нэмэлт өөрчлөлтийг нийт Төлөөлөгчдийн ердийн олонхийн саналаар батална.

5 дугаар зүйл. Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын анхдугаар хуралдаан

5.1. Анхдугаар хуралдааныг шинээр сонгогдсон төлөөлөгчдийн насаар хамгийн ахмад нь нээж удирдах бөгөөд дараах асуудлыг хэлэлцэнэ. Үүнд:

-Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн дүн, сонгогдсон Төлөөлөгчдийн бүрэн эрхийг хүлээн зөвшөөрүүлэх тухай дүүргийн сонгуулийн хорооны даргын илтгэл

- Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргыг сонгох

- Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Тэргүүлэгчдийг сонгох

- Дүүргийн Засаг даргад нэр дэвшүүлэх

5.2. Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн дүн, сонгогдсон төлөөлөгчдийн бүрэн эрхийг хүлээн зөвшөөрүүлэх тухай илтгэлийг дүүргийн сонгуулийн хорооны дарга тавих бөгөөд илтгэлтэй холбогдуулан асуулт тавина.

5.3. Асуулт асууж дууссаны дараа Төлөөлөгчдийн бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх тухай тогтоолыг батална.

5.4. Хурлын даргад нэр дэвшүүлэхдээ сонгуулийн дүнгээр тухайн хуралд хамгийн олон суудал авсан нам, эвсэл эхэлж нэр дэвшүүлэх эрхтэй

5.5. Хурлын төлөөлөгчид Хурлын даргад өөрийн болон бусад төлөөлөгчийн нэрийг дэвшүүлж болно.

5.6. Хурлын даргад нэг хүний нэр дэвшсэн бол илээр, хоёр ба түүнээс дээш хүний нэр дэвшсэн бол нууц санал хураалт явуулж, хуралдаанд оролцсон төлөөлөгчдийн олонхийн буюу 50-аас дээш хувийн санал авсан төлөөлөгчийг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргаар сонгогдсонд тооцож, тамга тэмдгийг гардуулна.

5.7. Хурлын даргад нэр дэвшсэн нэр дэвшигчдийн аль нэг нь олонхийн санал аваагүй бол санал тэнцсэн буюу хамгийн олон санал авсан хоёр төлөөлөгчийг хоёр дахь санал хураалтад оруулна. Тэдгээрийн хэн ч олонхийн санал аваагүй бол Хурлын даргад дахин нэр дэвшүүлэх ажиллагааг явуулна.

5.8. Хурлын төлөөлөгчид санал хураалтад оролцож зөвхөн нэг хүний төлөө санал өгөх ба нэр дэвшигч өөрөө санал хураалтад оролцох эрхтэй.

5.9. Хурлын дарга болон Хурлын тэргүүлэгчдийг сонгох, Засаг даргад нэр дэвшүүлэх санал хураалтыг зохион байгуулах Тооллогын комиссыг төлөөлөгчдийн саналаар байгуулж болно.

5.10. Хурлын Тэргүүлэгчдийг Хурлын даргыг оролцуулан 5-7 хүний төлөөлөгчийн бүрэлдэхүүнтэйгээр дөрвөн жилийн хугацаагаар сонгоно.

5.11. Дүүргийн Засаг даргад тухайн Хурал дахь нам, эвслийн бүлэг, эсхүл Хурлын төлөөлөгч нэр дэвшүүлэх эрхтэй. Дүүргийн Засаг даргад нэр дэвшигч нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 26 дугаар зүйл 26.5 дахь хэсэгт заасан шаардлагыг хангасан байна.

5.12. Дүүргийн Засаг даргад нэг хүний нэр дэвшсэн бол илээр, хоёр ба түүнээс дээш хүний нэр дэвшсэн бол нууц санал хураалт явуулж, хуралдаанд оролцсон төлөөлөгчдийн олонхийн буюу 50-иас дээш хувийн санал авсан нэр дэвшигчийг томилуулахаар Нийслэлийн Засаг даргад санал болгоно.

6 дугаар зүйл. Хурлын хуралдаанд асуудал оруулах эрх

6.1. Хурлын төлөөлөгч, Хурлын хороо, Нам, эвслийн бүлэг, дүүргийн Засаг дарга асуудал санаачлан Хуралд хэлэлцүүлэхээр оруулах эрхтэй.

6.2. Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэн Хуралд асуудал хэлэлцүүлэхээр санал дэвшүүлж болно.

6.3 Хуралдаанаар хэлэлцүүлэх асуудал тодорхой төсөв, зохион байгуулалт, хүн хүч шаардсан ажил бол дүүргийн Засаг даргын саналыг заавал авсан байх ёстой. Хурлын төлөөлөгчөөс санал авахаар ирүүлсэн асуудлын төслийг дүүргийн Засаг дарга судалж үзээд хуульд заагдсан хугацаанд санал өгөх ба хамгийн ойрын ээлжит хуралдаанд амжиж санал өгөөгүй бол дараагийн ээлжит хурлаас өмнө заавал санал өгсөн байна.

7 дугаар зүйл. Нам, эвслийн бүлэг байгуулах, түүний ажлын зохион байгуулалт

7.1. Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн дүнгээр Хуралд 3-аас доошгүй суудал авсан нам, эвсэл бүлэг байгуулсан тухай шийдвэр, бүлгийн гишүүдийн нэрсийн жагсаалтыг анхдугаар хуралдааны даргад өргөн мэдүүлнэ.

7.2. Анхдугаар хуралдааны дарга нам, эвслийн бүлэг байгуулсан тухай шийдвэр, түүний бүрэлдэхүүнийг хуралдаанд уншиж танилцуулах бөгөөд энэ асуудлаар аливаа хэлэлцүүлэг явуулахгүй.

7.3. Шинээр нөхөн сонгогдсон төлөөлөгч аль нэг нам, эвслийн бүлэгт нэгдэн орвол түүнийг албан ёсоор мэдээлнэ.

7.4. Нам, эвслийн бүлгийн ахлагчийг дотроосоо сонгоно.

7.5. Нам эвслийн бүлэг нь хэлэлцэж байгаа асуудалтай холбоотойгоор санал дүгнэлтээ гаргах, хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулах, ажлын хорооны хурлын үед болон хуралдааны үед завсарлага авах, Хурлын дарга, Тэргүүлэгчидтэй аливаа асуудлаар зөвшилцөх, Хурлын дарга, Тэргүүлэгчдийг сонгох, Засаг даргад нэр дэвшүүлэх, чөлөөлөх асуудалд санал өгөх эрхтэй.

7.6. Нам, эвслийн бүлэг нь өөрт ногдох дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд жил бүр эргэлтэд оруулах зарчим баримтлан нэр дэвшүүлж дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд оруулж санал хураалгана.

7.7. Хурлын шийдвэрийн төслийг нам, эвслийн бүлэг хэлэлцэж гаргасан дүгнэлтээ Хурлын хуралдаанд танилцуулна.

7.8. Нам, эвслийн бүлгүүд нь ажиллах журамтай байх бөгөөд ажиллах журмыг бүлгийн хуралдаанаар батална.

8 дугаар зүйл. Хурлын хороо, дэд хороо, түр хороодыг байгуулах ба тэдгээрийн ажлын зохион байгуулалт

8.1. Хурлын тасралтгүй, байнгын үйл ажиллагааг хангах, хуралдаанаар хэлэлцэх асуудлыг урьдчилан бэлтгэх, санал дүгнэлт гаргах, Хурлаас гарсан шийдвэрийн биелэлтийг хянан шалгах чиг үүрэг бүхий Хурлын хороог байгуулан ажиллана.

8.2. Хурлын хорооны тоо, хамаарах асуудал, бүрэлдэхүүний талаар төлөөлөгчдийн санал авч, Хурлын бүрэн эрхийн хугацаагаар төлөөлөгчдийн бүрэлдэхүүнтэйгээр байгуулна. Төлөөлөгч хоёроос илүүгүй хороонд харьяалагдана.

8.3. Хурлын хорооны хурлыг сард нэгээс доошгүй удаа хуралдаан, нам, эвслийн бүлэг, бусад хороодын хурлын товтой давхцуулалгүйгээр хийх бөгөөд хурлын хуралдаанаар хэлэлцүүлэх асуудалд санал, дүгнэлт өгнө.

8.4. Хурлын хорооны дарга, дэд хорооны даргыг тухайн хорооны Төлөөлөгчдийн дотроос сонгож, Хурал батална.

8.5. Хурлын төлөөлөгч бүх хороодын хуралд оролцож санал гаргах, үг хэлэх эрхтэй ба зөвхөн өөрийн харьяалагдах хорооны хуралд таслах эрхтэй оролцоно.

8.6. Хороо ба түүний хурал нь хурлын төлөөлөгчийн бүрэн эрхээ хэрэгжүүлэх үндсэн хэлбэрийн нэг бөгөөд Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.5, 12.1.7-12.1.9 дэх заалтуудад заасан хууль тогтоомж, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийн биелэлт ба албан тушаалтан, аж

ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд шалгалт хийх, тэдгээрээс илтгэл, сонсгол, асуулгын хариу авах ажлыг хийх арга болно.

8.7. Хороо нь тэдгээрийн хурлаар хэлэлцсэн асуудлын талаар хурлын хуралдаанд илтгэл тавьж болох ба жил бүрийн үйл ажиллагааны тайланг хуралдаанд оруулж хэлэлцүүлнэ.

8.8. Хороо нь өөрийн ажлын зохион байгуулалт, хурлын журмыг энэхүү дэгт нийцүүлэн гаргах ба сар бүрийн хурлын товыг энэ зүйлийн 8.3 дахь хэсэгт заасныг баримтлан Хурлын даргатай зөвшилцөн тогтооно.

8.9. Хурлаас цаг үеийн асуудлыг судлах, санал дүгнэлт боловсруулах, хянан шалгах үүрэг бүхий түр хороо, ажлын хэсэг байгуулан ажиллуулж болно. Түр хороо, ажлын хэсгийн бүрэлдэхүүнд тодорхой чиглэлээр мэргэжлийн байгууллагын туслалцаа авах, мэргэжилтэн, зөвлөх, асуудал хариуцсан ажилтан нарыг оруулах ба тэдгээрийн ажлын үр дүнг харьяалах хорооны хурлаар хэлэлцүүлж шаардлагатай тохиолдолд хурлын хуралдаанд оруулна.

8.10. Хурлын хороод нь хэлэлцсэн асуудлаараа санал дүгнэлт, зөвлөмж гаргах ба шаардлагатай бол эдгээрийг Хурлын хуралдаанд оруулж шийдвэр гаргуулна. Шийдвэрийн төслийг тухайн хорооны дарга Хурлын даргад өргөн барина.

9 дүгээр зүйл. Хуралдааны шийдвэр

9.1. Хурал хэлэлцсэн асуудлаар тогтоол гаргах бөгөөд тогтоолыг тухайн Хурлын хуралдаанд оролцсон Төлөөлөгчдийн олонхийн саналаар батална.

9.2. Хурлын тогтоолд Хурлын дарга, Хурлын даргыг сонгох, чөлөөлөх тухай тогтоолд тухайн хуралдаан даргалагч тус тус гарын үсэг зурна.

9.3. Хурлын шийдвэрийг ёсчлон баталсан даруйд дүүргийн Засаг даргад ажлын гурав хоногийн дотор нэг хувийг хүргүүлж, олон нийтэд мэдээлнэ.

9.4. Хурлын шийдвэр нь хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрт нийцээгүй бол түүнийг Хурал өөрчлөх буюу хүчингүй болгоно.

10 дугаар зүйл. Хурлын шийдвэрт хориг тавих

10.1. Хурал Үндсэн хууль, бусад хууль тогтоомж зөрчсөн эсхүл өөрийнх нь бүрэн эрхэд үл хамаарах, түүнчлэн хэрэгжих санхүүгийн болон бусад эх үүсвэргүй шийдвэр гаргасан бол Засаг дарга холбогдох шийдвэрт бүхэлд нь буюу түүний зарим хэсэгт хориг тавих эрхтэй.

10.2. Засаг дарга Хурлын шийдвэрт хориг тавьсантай холбоотой харилцааг Монгол Улсын Засаг Захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 27-р зүйлд заасан журмаар шийдвэрлэнэ.

11 дүгээр зүйл. Хуралдааны бэлтгэл ажиллагааг хангах журам

11.1. Монгол улсын Үндсэн хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, бусад хуульд хэлэлцэхээр заасан асуудлууд, Хурлын байгууллагаас сонгуулийн бүрэн эрхийн хугацаанд хэрэгжүүлэх ажлын үндсэн чиглэл, Хурлын Тэргүүлэгчдийн ажлын төлөвлөгөөнд тусгагдсан асуудлуудыг ээлжит хуралдааны хугацаанд хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэнэ.

11.2. Хуралдаанаар хэлэлцэх асуудалтай холбогдуулан илтгэл, гарах шийдвэрийн төслийг асуудал оруулж байгаа Төлөөлөгч болон Хурлын ажлын алба, Засаг дарга түүний Тамгын газар боловсруулна.

11.3. Хуралдаанаар хэлэлцэх асуудлыг тухайн асуудал эрхэлсэн хорооны хурлаар урьдчилан хэлэлцэж, нэгдсэн санал дүгнэлтийг хуралдаанд оруулна.

11.4. Хуралдаанаар хэлэлцэх асуудлын талаар бэлтгэл ажлын төлөвлөгөө гаргах, хорооны санал дүгнэлт бэлтгэх, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах ажлыг тухайн хорооны дарга, Хурлын ажлын алба, нам, эвслийн бүлгийн ажлын алба тус, тусын үүргийн дагуу хариуцна.

11.5. Хуралдаанаар хэлэлцэх асуудалд холбогдох тооцоо, судалгаа, лавлагаа, гарах шийдвэрийн төслийг хавсаргаж хуралдаан болохоос 5-аас доошгүй хоногийн өмнө Хурлын төлөөлөгчдөд тараах бөгөөд энэхүү шаардлагыг хангаагүй асуудлыг хуралдаанаар хэлэлцэхгүй. Ээлжит бус хуралдаанаар хэлэлцэгдэх асуудалд дээрх хугацаа хамаарахгүй.

11.6.Хуралдаанд хэлэлцэх асуудалтай холбогдуулан хуралдаанд урилгаар оролцох албан тушаалтны нэрсийг Хурлын дарга, Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргатай зөвшилцөн урилгыг Хурлын ажлын албанаас 2-оос доошгүй хоногийн өмнө хүргүүлнэ.

11.7. Хуралдааныг хэвийн явуулах бэлтгэлийг хангах, хүндэтгэлийн туг, сүлд болон шаардлагатай техник тоног төхөөрөмжийг Хурлын ажлын алба, Засаг Даргын Тамгын Газар урьдчилан хангасан байна.

11.8. Хуралдаанаар тодорхой асуудал хэлэлцэх журмыг /тухайлбал дүүргийн төсөв хэлэлцэх гэх мэт/ Хурал өөрөө тогтоож болно.

11.9. Энэ зүйлийн 11.6 дахь хэсэгт заасан хурлын төлөөлөгчдөд тараасан хэлэлцэх асуудлын баримт бичгүүдтэй танилцах боломжийг иргэдэд олгох зорилгоор сандал, ширээ бүхий тусгай өрөө, танхимыг ажлын цагаар гаргаж өгөх ба иргэд хүсвэл хуулбарлаж өгнө. Мөн олон нийтэд нээлттэй цахим хуудсанд байршуулна.

12 дугаар зүйл. Хурлын хуралдааныг зохион байгуулах журам

12.1. Хурлын хуралдааныг нээлттэй, хаалттай хэлбэрээр зохион байгуулж болно.

12.2. Нээлттэй хуралдааны үед дараах журмаар хуралдааны ажиллагааг зохион байгуулна. Үүнд:

12.2.1.хурлын төлөөлөгчид, урилгаар оролцогсод, хэвлэл мэдээллийн ажилтнууд, иргэдийн төлөөлөл хуралдаан эхлэхээс өмнө суудлаа эзэлсэн байна. Хуралдааны ирц, урилгаар суугчдын талаар Хурлын ажлын албанаас хурал даргалагчид урьдчилан мэдэгдэх,

12.2.2. хуралдаан эхлэхийн өмнө танхимд Монгол улсын төрийн сүлд дууллыг эгшиглүүлнэ.

12.2.3.хуралдаан даргалагч хуралдааныг нээж товч үг хэлэх бөгөөд Төлөөлөгчдийн ирц, урилгаар оролцож байгаа хүмүүсийн талаар танилцуулна. Төлөөлөгч өвчтэй хүн асарч байгаа, гадаад, дотоод томилолттой байгаа эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр чөлөөтэй байгааг хүндэтгэн үзэх шалтгаанд тооцох,

12.2.4.хуралдааны даргалагч дараалал хэлэлцэх асуудлыг танилцуулж батлуулах,

12.2.5.хэлэлцэх асуудалтай холбоотой илтгэл, сонсгол мэдээлэл нь Төлөөлөгчдөд урьдчилан тараасан бол түүнийг бүтнээр нь сонсохгүйгээр тайлбар авч, санал, дүгнэлтийг нэгтгэн сонсож, гарах шийдвэрийн төслийг хэлэлцэнэ. Хуралдаанаар хэлэлцэж байгаа асуудалд холбогдох зураг, хүснэгт, танилцуулга, дүрс ба дууны бичлэг, видео бичлэг, биет зүйлс түүний загвар хэсгийг хуралдаанд үзүүлж болно.

12.3. Төлөөлөгчид хуралдаанд оролцохдоо хуралдааны дэг, хуралдааны даргын шаардлагыг биелүүлэх үүрэгтэй бөгөөд үг хэлэх, санал шүүмжлэл гаргах, асуулт тавих эрхийг дараах байдлаар эдэлнэ. Үүнд:

12.3.1. үг хэлэх, асуулт асуухаа урьдчилан мэдэгдэн дараалалд орж хуралдаан даргалагчаас зөвшөөрөл авах,

12.3.2. тогтоосон хугацаанд өөрөө үг хэлэх, асуулт асуух энэхүү эрхээ бусад төлөөлөгчдөд шилжүүлэхгүй байх,

12.3.3. хуралдаан даргалагч зөвшөөрөл өгөөгүй байхад үг хэлэх буюу асуулт тавих энэхүү эрхээ эдлэхдээ бүдүүлэг үг хэллэг хэрэглэх бусдыг доромжлох, нэр төрийг нь гутаах, басамжлах, яриаг нь таслах өмнөөс нь үг хэлэх өөрийн саналыг дэмжүүлэх буюу бусдын саналыг үгүйсгэх зорилгоор дүр үзүүлэх, хүч хэрэглэх зэрэг үйлдэл гаргахгүй байх,

12.3.4. төлөөлөгч хэлэлцэж байгаа асуудал бүрээр эхний удаад 5 минут, дараагийн удаад 3 минут хүртэл хугацаагаар үг хэлнэ. Үг хэлэх хугацааг тухайн хэлэлцэх асуудлаас шалтгаалан тухайн хуралдаанаас тогтооно.

12.3.5. төлөөлөгч хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан төр захиргааны албан тушаалтанд хандаж асуулга тавьж хариу авч болно.

12.4. Хэлэлцэж байгаа асуудлаар Төлөөлөгчдийн гаргасан горимын саналыг сонсох, түүгээр санал хураалгаж болно. Горимын санал гэж хуралдаанаар тухайн асуудлыг хэрхэн хэлэлцэж шийдвэрлэх талаар Төлөөлөгчдөөс гаргасан саналыг ойлгоно.

12.5. Хуралдааны санал шүүмжлэлийг төлөөлөгчдийн олонхийн саналаар тасална. Шаардлагатай гэж үзсэн цөөнхийн саналыг тусгайлан хэлэлцэж хуралдааны шийдвэрт болон тэмдэглэлд тусгана. Төлөөлөгч нь санал шүүмжлэлээ бичгээр гаргаж болно.

12.6. Тодорхой асуудал хэлэлцэх явцад шаардлагатай бол намын бүлгийн завсарлага авах, төлөөлөгчдийн олонхийн саналаар хуралдааныг түр завсарлуулах ба хугацааг нь сунгаж болно.

12.7. Хурлын тогтоол бусад баримт бичгийн төслийг нарийвчлан хянаж Төлөөлөгчдийн санал шүүмжлэлийг тусгаж нягтлан боловсруулах зорилгоор хуралдаанаас гарах шийдвэрийн төслийг боловсруулах ажлын хэсгийг байгуулж болно.

12.8. Төлөөлөгч нь хуралдаанд хэлэлцүүлэхээр тогтоолын төсөл оруулах, тогтоолын төсөлд нэмэлт өөрчлөлт оруулах, засвар хийх эрхтэй. Тогтоолын төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай саналыг төлөөлөгчдөөр хэлэлцүүлж, тэдний олонхийн саналаар шийдвэрлэнэ.Цөөнхийн саналыг тэмдэглэлд бичиж шаардлагатай гэж үзвэл хуралдааны шийдвэрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд оруулж асуудлыг шийдвэрлэх

арга хэмжээ авна. Хэрвээ хүсвэл санал хураалтаар цөөнх болсон төлөөлөгчдийн тайлбарыг сонсож дахин санал хураалт явуулж болно.

12.9. Хуралдааны дарга нь бичгээр санал, асуулт, асуулгын талаар төлөөлөгчдөд сонгох, танилцуулж хэлэлцүүлэх, хэлэлцсэн асуудлаар төлөөлөгчдийн саналыг хурааж дүнг мэдээлж эцсийн шийдвэрийг батлуулна.

12.10. Хуралдааны тов, хэлэлцэх асуудлыг хурлын вебсайтад байрлуулж, урьдчилан танилцах боломжийг бүрдүүлнэ.

12.11. Иргэн, аж ахуйн нэгж байгууллагын тавьсан санал хүсэлт, өргөдөл, гомдлыг хүлээн авч хэрхэн хэлэлцэх журмыг хурал өөрөө тогтоож мөрдөнө.

13 дугаар зүйл. Нээлттэй хуралдааны дэг

13.1. Нээлттэй хуралдаанд хэлэлцэж байгаа асуудлыг боловсруулахад оролцсон ажлын хэсгийн бүрэлдэхүүн, түүнчлэн хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөлөгчид, иргэдийн төлөөлөл ажиглагчаар оролцож болно.

13.2. Нээлттэй хуралдааны явцыг дуу, дүрс бичлэг, мэдээллийн бусад хэрэгслийг ашиглан бэхжүүлнэ.

13.3. Нээлттэй хуралдаанд ажиглагчаар оролцох иргэдийн хүсэлтийг урьдчилан авах бөгөөд эхэлж хүсэлт тавьсан иргэдийн төлөөллийг оролцуулна.

13.4. Төлөөлөгчид болон хуралдааны бусад оролцогчид хуралдааны танхимд орохдоо гар утсаа унтраасан байна.

14 дүгээр зүйл. Хаалттай хуралдааны дэг

14.1. Хуралдаанд оролцсон төлөөлөгчдийн олонхийн саналаар асуудлыг хаалттай хуралдаанаар хэлэлцэж болно.

14.2. Хаалттай хуралдаанаар дүүргийн Засаг дарга, тухайн асуудлыг хариуцсан байгууллагын дарга, Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга, ажлын албаны нууцыг хариуцсан ажилтан, түүнчлэн тухай асуудлыг боловсруулахад оролцсон ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг оролцуулж болно.

14.3. Шаардлагатай тохиолдолд энэ зүйлийн 14.2-д зааснаас бусад хүнийг хаалттай хуралдаанд оролцуулж болох бөгөөд хуралдаанд оролцогчдоос нууц задруулахгүй байх баталгааг урьдчилан гаргуулна.

14.4. Хаалттай хуралдаанд дуу, дүрс бичлэг хийх, гар утас авч орох, утсаар ярихыг хориглоно.

14.5. Хаалттай хуралдааны талаар зөвхөн нууцын дэвтэрт тэмдэглэл хийх бөгөөд шүүхийн шийдвэрээр дэлгэхээс бусад тохиолдолд нийтэд дэлгэхгүй.

15 дугаар зүйл. Хуралдаан даргалагчийн эрх, үүрэг

15.1. Хуралдааныг Хурлын дарга, түүний эзгүйд Хурлын даргын санал болгосноор Тэргүүлэгчдийн аль нэг нь нээж удирдана. Хурлын даргад гэнэтийн давагдашгүй хүчин зүйл тохиолдсон үед насаар хамгийн ахмад иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгч хуралдааныг удирдана. Хуралдааныг зохион байгуулах талаар хуралдаан даргалагч дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

15.1.1. хуралдааны товыг тогтоон зарлаж бэлтгэлийг хангах,

15.1.2. хуралдааныг товлосон цагт эхлүүлж дэгийн дагуу зохион байгуулж, зөрчигдвөл таслан зогсоох ,

15.1.3 саналаа ирүүлсэн дарааллыг баримтлан төлөөлөгчдөд асуулт асуух, үг хэлэх зөвшөөрөл өгөх,

15.1.4 төлөөлөгчдөөс гаргасан горимын саналаар санал хураалт явуулах,

15.1.5. санал хураалт явуулж, дүнг мэдээлэх,

15.1.6. хуралдааны шийдвэрийг хэлбэржүүлэх ажлыг зохион байгуулах,

15.1.7. ирц хүрэлцэхүйц байвал хүндэтгэх шалтгаантай төлөөлөгчид чөлөө өгөх,

15.1.8. хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх, үүрэг

15.2. Асуудлыг хэлэлцэх журам, дарааллын талаар төлөөлөгчөөс гаргасан саналыг горимынх гэх бөгөөд түүгээр нэг удаа санал хураана.

15.3. Хурлын хуралдааны явцыг Улаанбаатар телевиз болон бусад телевизээр дамжуулах, Тэргүүлэгчдийн хурал болон хороо, дэд хороодын хуралдааныг хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр сурталчилах ажлыг зохион байгуулна.

16 дугаар зүйл. Хуралдааны тэмдэглэл хөтлөх журам

16.1. Хуралдаан бүр дээр түүний үйл ажиллагааг нарийн тэмдэглэсэн тэмдэглэлийг хөтөлнө. Үүнд:

16.1.1. Хуралдааны дугаар, хуралдаан хийсэн он , сар, өдөр

16.1.2. Хуралдааны ажиллагаа эхэлсэн, дууссан, илтгэл, хавсралт илтгэл, санал , шүүмжлэл, асуулт, хариулт, асуулга, тайлбар, лавлагаа өгсөн хугацааны хамт тэмдэглэнэ.

16.1.3. Хуралдааны ирц тоо, хувиар байхгүй байсан төлөөлөгчийн нэр, шалтгаан,

16.1.4. Хуралдаан нээсэн хүний овог нэр, хуралдааны даргад хэний саналаар, ямар албан тушаалтай, хэн хэнийг сонгосон,

16.1.5. Илтгэл, хавсралт илтгэл, бусад асуудлыг ямар албан тушаалтай хэн оруулсан,

16.1.6. Илтгэгчдээс асуусан асуулт, түүнд өгсөн хариулт,

16.1.7. Санал, шүүмжлэл гаргасан төлөөлөгч, урилгаар оролцсон хүмүүсийн нэр, албан тушаалт,

16.1.8. Хуралдааны ажиллагааны явцад тавигдсан асуулга, түүнд хуралдаан дээр өгсөн бол гол утга

16.1.9. Баталсан шийдвэрүүдийн нэр, хурлын тогтоолуудыг хэлэлцүүлж батлуулсан журам, саналын дүн,

16.1.10. Хуралдааны явцад хэлэлцсэн, сонордуулсан, тараасан баримт бичиг,

16.1.11. Төлөөлөгчид тусгайлан тэмдэглүүлэхээр өөрөө бичсэн зүйл,

16.1.12. Хуралдаанд хоцорч ирсэн, чөлөө авсан, өвчтэй байсан, тасалсан, хуралдааны даргын зөвшөөрөлгүйгээр гарч явсан төлөөлөгчийн нэр, цаг минут,

16.1.13. Төлөөлөгчдийн хуралдаанд хэлсэн үгийг тодорхой бичих бөгөөд тусгайлан тэмдэглүүлсэн зүйлийг тухайн төлөөлөгчдөд хянуулж гарын үсэг зуруулна.

16.1.14. Хуралдааны тэмдэглэл дарга гарын үсэг зурж, хуралдааны материалд хавсаргана.

16.2. Хуралдааны тэмдэглэл нийтэд нээлттэй байх бөгөөд хувилж авахыг хүссэн иргэн нь хуулбарлах зардлыг өөрөө хариуцана.

16.3. Хуралдааны тэмдэглэл хуулбарлан өгөх зардлын жишгийг Хурлын тэргүүлэгчид тогтоох бөгөөд “хуулбар үнэн” гэсэн тэмдгийг Хурлын ажлын алба дарж өгнө.

17 дугаар зүйл. Хурлын шийдвэрийг зохион байгуулах

17.1. Хуралдааны тогтоолыг мөрдөх хугацааг жичид нь заагаагүй бол уг хуралдаан болсон өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөнө.

17.2. Хуралдааны шийдвэрийг мэдээлж сурталчлах, биелэлтийг зохион байгуулах ажлыг Тэргүүлэгчид, Хурлын төлөөлөгч, Хурлын ажлын алба, Засаг дарга түүний Тамгын газар, хэлтэс албад, хэвлэл мэдээллийн байгууллага хариуцна.

17.3. Хуралдааны тухай мэдээ, хуралдаанд оруулсан илтгэл, тогтоолыг Хурлын ажлын албанаас 5 хоногийн дотор хэвлэлд нийтлэн, вебсайтад байршуулж сурталчилна. Хурлын шийдвэрийг хэвлэлд нийтлэх, холбогдох байгууллагад хүргэх асуудлыг Хурлын дарга, Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын зөвшөөрлөөр хийнэ.

17.4.Хуралдаан дууссанаас хойш 10 хоногийн дотор хуралдааны үр дүнг хэлэлцэх, хурлын тогтоолын биелэлтэнд хяналт тавих, нийтэд мэдээлнэ.

17.5.Хуралдааны шийдвэрийг хэрэгжүүлж байгаа ажлын явц, үр дүнгийн талаар дүүргийн Засаг дарга, түүний Тамгын газрын дэргэдэх газар, алба, дүүрэг, дэвсгэртээ оршиж байгаа албан байгууллага, аж ахуйн нэгж дээр шалгах, тэдгээрийн удирдлагуудын илтгэл, сонсголыг хэлэлцэх ажлыг хийж дүгнэлт өгч байна.

17.6.Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн дагуу хурлын шийдвэр биелүүлээгүй албан тушаалтанд хариуцлага тооцож байна.

17.7.Хурлын шийдвэрийн биелэлтийн талаар Хурал түүний Тэргүүлэгчид тусгайлан хэлэлцэж чиглэл өгөх, хугацаатай даалгавар өгөх, шаардлага тавих, хариуцлага тооцох зэргээр ажиллаж гаргасан шийдвэрээ ажил хэрэгч болгохын төлөө ажиллана.

18 дугаар зүйл. Төсвийн төсөл боловсруулах, батлахтай холбогдсон харилцаанд оролцох ажил

18.1 Дүүргийн төсөв, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төсвийн төслөө Хурлаар заавал хэлэлцүүлсний үндсэн дээр санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

18.2 Үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөө ба жилийн төсвийн төслийг боловсруулахдаа есдүгээр сарын нэгний өдрөөс аравдугаар сарын арван тавны өдөр хүртэлх хугацаанд иргэдийн саналыг нээлттэй авсан байх ёстой бөгөөд Хурлын төлөөлөгчөөс бичгээр өгсөн саналыг хэрхэн тусгасан талаар хариу заавал мэдэгдэнэ.

19 дүгээр зүйл. Онцгой үеийн шийдвэр гаргах ажиллагаа

19.1. Байгалийн гамшиг, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал, гал түймэр зэрэг нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдалд заналхийлсэн аливаа үзэгдэл, үйлдлийн эсрэг авсан шуурхай арга хэмжээтэй холбоотойгоор дүүргийн Засаг дарга захирамж гаргасан бол Хурлын даргад нэн даруй мэдэгдэж хүргүүлнэ.

19.2. Энэ зүйлийн 20.1 дэх хэсэгт заасан мэдэгдлийг хүлээн авсан даруйд Хурлын тэргүүлэгчдийн хурлыг Хурлын дарга зарлах ба Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар дүүргийн Засаг даргын гаргасан захирамжийг авч хэлэлцэж тодорхой шийдвэр гаргана.

19.3. Хурлын тэргүүлэгчдийн хурлаар ээлжит бус хуралдааныг хуралдуулах зар ба хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг баталж болно.

19.4. Онцгой дэглэм тогтоосон, гэнэтийн аюулын үр дагаврыг арилгахтай холбогдуулан түр журам гаргасан, нийтийг хамарсан эмх замбараагүй байдлыг таслан зогсоох, даамжрахаас урьдчилан сэргийлэх зорилгоор гаргасан дүүргийн Засаг даргын захирамжийг хэлэлцэхдээ нөхцөл байдлын тухай дэлгэрэнгүй мэдээллийг нутаг дэвсгэрийн цагдаа, онцгой байдал, мэргэжлийн хяналт, хүн ба мал эмнэлгийн газар зэргээс авсны үндсэн дээр бодитойгоор үнэлж шийдвэр гаргана.

20 дугаар зүйл. Хурлын дэг хүчин төгөлдөр болох

20.1 Энэхүү Хурлын дэг батлагдсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилнэ.

-оо000оо-